ХЭНТИЙ АЙМГИЙН
ЖАРГАЛТХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 06 өдөр Дугаар А/01 Жаргалтхаан

2025 оны цэргийн бүртгэл явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4, Цэргийн албаны тухай хуулийн 34 дүгээр зүйл, Аймгийн Засаг даргын 2024 оны А/675 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2025 оны цэргийн бүртгэлийг сумын хэмжээнд 2025 оны 01 дүгээр сарын 06-ний өдрөөс 01 дүгээр сарын 20-ны өдрүүдэд зохион байгуулсугай.
2. Цэргийн бүртгэлийг зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: С.Мөнхдэлгэр – Засаг даргын Тамгын газрын дарга
Нарийн бичгийн дарга: Н.Энхзул – Архив, бичиг хэргийн эрхлэгч
Гишүүд: Д.Энхболд – 1 дүгээр багийн Засаг дарга
Э.Аранжал – 2 дугаар багийн Засаг дарга
М.Өсөхжаргал – 3 дугаар багийн Засаг дарга
Б.Мэндбаяр – 4 дүгээр багийн Засаг дарга
Б.Жаргал – 5 дугаар багийн Засаг дарга
Н.Уганбаяр – Газрын даамал

3. Цэргийн үүрэгтэн иргэдийг биечлэн болон цахимаар бүртгэж, тоо бүртгэлийг 2024 оны жилийн эцсийн хүн амын тоотой тулган тоо бүртгэлийн материал, мэдээ судалгааг маягтын дагуу гаргаж хугацаанд нь аймгийн Цэргийн штабт хүргүүлэхийг комисс (С.Мөнхдэлгэр)-т үүрэг болгосугай.

ДАРГА С.ГАНБАТ

Data (D:) /A4 zahiramj/